



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 8/74

Улаанбаатар хот

Г Тэмдэг, хэвлэмэл хуудас хариуцах албан Тушаалтныг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх тухай заавар"-ын 4.37-д заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тэмдгийг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулгаар түшүүлсүгэй.
2. Албан хэрэгцээнд ашиглах нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаал, албан бичгийн А4, А5 хэвлэмэл хуудсыг Бичиг хэрэг, архивын эрхлэгч, ахлах ахлагч А.Тунгалаг,

Нууц, маш нууц, онц чухал нууцын тэмдгийг Дотоо хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч Ж.Төмөрмандах,

Барилгын зураг төслийн хяналтын байцаагчийн тэмдэг, хэвлэмэл хуудасыг Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа Л.Тэгшбаяр,

Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн тэмдэг, хэвлэмэл хуудасыг Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал, дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч Э.Энх-Амгалан,

Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн тэмдэг, хэвлэмэл хуудасыг Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч Б.Мягмаржав нарт хариуцуулсугай.

3. Байгууллагын тэмдгийг даргын гарын үсэгтэй баримт бичигт тод тэгш дарах, зориулалтын саванд хадгалах, хэвлэмэл хуудсыг тусгай дугаарлагчаар дугаарлан хадгалалт, хамгаалалт, ашиглалт зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг дээрх бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 11 сарын 16-ны өдрийн А/123 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧУЛТЭМСҮРЭН

0117155601
ХАДСН 9077073